

Төслийн нэр: "Ханан дахь тоглоом "

Хэсэг I: Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг/ хот: Ховд
Сум /дүүрэг: Алтай
Сургууль, СЭЭБХ-ны хаяг: Ховд аймгийн Алтай сум Тахилт багт
СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Хожоо овогтой Шинэбаяр

Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Дотоод хүчин зүйлс	
<p>Давуу тал</p> <ol style="list-style-type: none"> Бага ангийн сурагчдын унших бичих чадварт ахиц гарсан. Багаар хамтарч ажиллаж байна. Багш нар хичээлээ бэлтгэл сайтай заадаг. Эцэг эхчүүд сургуультай хамтарч ажиллаж байна. Хичээлийн цагийг нарийн баримталдаг. Сургуулийн хичээлийн жилийн зорилгоо зөв тодорхойлж чадсан. 	<p>Сул тал</p> <ol style="list-style-type: none"> Сургууль дээр бага ангийн сурагчдын сонирхлыг татах сайхан орчин бүрдээгүй. Анхаарал татахуйц зүйл байхгүй. Сурагчдын бие даан суралцах чадвар сул. Гэрийн даалгавар хийдэггүй. Бага ангийн нийт сурагчдын 90% нь бодлого бодож чаддаггүй. Тийм арга барил эзэмшээгүй. Ээж аавууд нь даалгаврыг нь хийлгэе гэвч яаж бодох аргыг нь мэддэггүй. Хичээлийн хэрэглэгдэхүүн шаардлага хангахгүй. Бага ангийн Математикийн хичээлийн хэрэглэгдэхүүн бараг байдаггүй. Сурагчдын тооцоолон бодох чадвар сул. Амьдрал дээр сурснаа хэрэглээ болгож чаддаггүй. Эцэг эхийн анхаарал халамж сул. Гэрийн даалгавар хийлгэхэд эцэг эхчүүдийн мэдлэг чадвар муу. Сурагчдын сэтгэн бодох чадвар сул. Ямарваа нэгэн зүйлийг хийсвэрлэн сэтгэх, ургуулан бодох тал дээр дутагдалтай, мэдлэгээ хэрэглээ болгож чаддаггүй. Багш нарын цалин хангамж муу. Ажиллах орчин, сургалтын хэрэглэгдэхүүн шаардлага хангахгүй. Багш нарыг урамшуулах, ажлын үр дүнг үнэлэх арга дутагдалтай.
Гадаад хүчин зүйлс	
<p>Боломж</p> <ol style="list-style-type: none"> Бага ангийн багш нар дунд ангийн мэргэжлийн багш нар эцэг эхчүүд, хамтарч ажилласнаар сурагчдын сурлаганд ахиц гарна. Алслагдсан аймаг, сум гэх нэрийдлээр бүх зүйлээс хоцрогдмол байсан. Одоо зам харилцаа сайжирсан цахим сүлжээнд холбогдсон тул өөрчлөгдөх бүрэн боломжтой. Багш нарт их сургуулийн болон мэргэжлийн багш нарыг авчран сургалт явуулбал арга зүй, заах арга барил сайжирна. Ингэснээр хүүхдэд хүрэх үр дүн сайжирна. Эцэг эхчүүдтэйгээ хамтран ажиллаж тэдний итгэлийг хүлээж тэдний нөөц боломжийг ашиглан хамтран ажиллавал хүүхдийн сургалтын орчин сайжирч сурлагын чанарт ахиц гарна. Эцэг эхчүүдтэй хамтран гарын доорх материал ашиглан, хичээлийн хэрэглэгдэхүүнийг хүүхдийн сонирхол татахуйц хийж тэдний нүдэнд байнга харагдах газар байрлуулж сургалтад ашиглавал хүүхдийн сурах идэвх сонирхол сайжирна. Сургуулийн орчин сайжирвал хүүхэд сургуульдаа ирэх дуртай болно. 	

- Давуу талаа бататгахад чиглсэн үйл ажиллагаа
- Сул талаа давуу тал болгоход чиглэсэн үйл ажиллагаа
- Боломжийг ашиглахад чиглэсэн үйл ажиллагаа

Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	Бага ангийн сурагчдын математик сэтгэлгээг хөгжүүлэх, сонирхлыг татахуйц шинэлэг ханын тоглоомыг эцэг эхийн оролцоотой байгуулж сургуулийн орчныг сайжруулах замаар сурагчдын сурлагын амжилтыг ахиулахад хувь нэмэр оруулна.
Хамрагдах хүний тоо	Бага ангийн 13 багш, 329 суралцагч, Насан Туршийн Боловсролын 56 суралцагч, эцэг эхчүүд, СЭЭБХ-ны гишүүд, сургуулийн удирдлагууд.

Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

ДД	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төслийн нээлт	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд	2019.9-р сар	Хөтөлбөр гаргаж сумын хэмжээнд зохион байгуулна.
2.	Математик сэтгэлгээ хөгжүүлэх ханын тоглоом байгуулах бэлтгэл	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд	6-р сар	СЭЭБХ-ны эцэг эхчүүдийн тусламжтайгаар бага ангийн хүүхдүүдэд зориулсан ханын тоглоомын булан сургуульд байгуулах ажлын бэлтгэл хийнэ.
3.	Ханын тоглоомын буланг сургууль дотор хаана байрлуулахыг шийдэх	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд, сургуулийн захиргаа	6-р сар	Сургуулийн захиргаанд хандан зурагт харуулсан тоглоомыг хаана байрлуулах талаар зөвшилцөж тохирно.
4.	Нийгмийн ажилтантай хамтран эцэг эхчүүдтэй уулзалт зохион байгуулах	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд, нийгмийн ажилтан	6-р сар	Эцэг эхчүүдээс мужааны ур чадвартай хүмүүсийг сонгон тоглоом хийх баг бүрдүүлнэ.
5.	Эцэг эхийн баг багш нартай хамтран ажиллах	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд	6-7-р сар	Математик, хөдөлмөрийн багш нартай, тоглоомоо хананд тааруулах, ямар хэмжээтэй хийх талаар хамтран ажиллана.
6.	Ханын тоглоом хийхэд шаардлагатай материалын жагсаалт гаргаж, худалдан авах	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд, эцэг эхчүүдийн баг	6-7-р сар	Материалын жагсаалт, үнийг судалж тооцоолно.
7.	Ханын тоглоомыг хийж байрлуулах	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд, эцэг эхчүүдийн баг	7-8-р сар	Бэлэн болсон тоглоомыг байрлуулж дуусгана.
8.	Ханын тоглоомоороо хүүхдүүд эцэг эхтэйгээ тоглох боломжийг	СЭЭБХ-ны Зохицуулагч,	9-р сар	Хүүхдүүд ханан дахь тоглоомоороо дуртай үедээ

	бүрдүүлэх, төлөвлөгөө гарган ажиллах	сургалтын менежер		тоглосноор сэтгэн бодох чадварт нь ахиц гарна.
9.	Эцэг эхчүүдэд тоглоомоо танилцуулан тэдний тусламжтай тоглоомоо баяжуулах	СЭЭБХ-ны гишүүд	тогтмол	Эцэг эхчүүдийн сургуульд хандах хандлага өөрчлөгдөнө.
10.	Төслийн үйл явцыг дүгнэх уулзалт, явцын эхний тайлан Дунд хугацааны дүгнэх уулзалт Төслийн хаалт	СЭЭБХ-ны УЗ	2019.11-р сар 11-р сар 2020.4-р сар	Эцэг эх, багш, сургуулийн удирдлагыг оролцуулан дүгнэх уулзалт зохион байгуулж, үйл явцыг сайжруулах санал зөвлөмжийг авч дараагийн хичээлийн жилд хэрэгжүүлнэ. Энэ хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг СЭЭБҮНХ-д хүргүүлнэ.
11.	Төслийн дунд болон эцсийн тайлан хүргүүлэх	СЭЭБХ-ны УЗ	2019.11-р сар 2020.5-р сар	Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг СЭЭБҮНХ-д хүргүүлнэ.



Хэсэг IV Зардлын задаргаа (1 хуудас байна)

Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Тус бүрт нь хүрэх үр дүнг бичнэ. (Хүүхдэд ямар бодит үр дүн авчрах, ямар чадварыг эзэмшүүлэх)	
Ханын тоглоом хийх материал, үнийн төсөөлөл	Зиг заг хавтан	ш	10	100 000	1 000 00	Сургуулийн бага анги байдаг коридорын хананд 3-4 төрлийн шинэлэг ханын багц тоглоомууд хийж байрлуулснаар хүүхдүүд дуртай үедээ тоглож тоглонгоо хөгжин сэтгэн бодох чадвар нь сайжирч хичээлдээ дуртай болно. Улмаар сурлагын амжилтанд ахиц гарна.
	Акустик эсгий	ш	6	80 000	480 000	
	Банз хуш	ш	2	30 000	600 000	
	Эрэг боолт шруп	хайрцаг	3	30 000	90 000	
	Тогтоогч зангуу товч	боодол	1	100 000	100 000	
	Бийр,багс,лак, боронз нэмэлт хэрэглэгдэхүүн	ш	1	100 000	100 000	
	Төрөл бүрийн өнгийн нимгэн эсгий	ш	10	20000	200 000	
	Самбарын гэрэлтүүлэг	ком	3	100 000	300 000	
	панер	удаа	3	60000	180 000	
	Бусад шаардлагатай зүйлс				500 000	
Ховдоос Алтай суманд авч материалаа авч ирэх тээврийн зардал	удаа	1	300 000	300 000		
Хананд тогтоох тоглоом худалдан авах	ш	3 багц	361 186	583 560	Интернэтээс судалж, хүүхдийн тоглоомын хэсгүүдийг худалдан авч ханын тоглоомонд байрлуулна.	
Баннер хэвлүүлэх	ш	1	60000	60 000	Төслийн хугацаанд бүх үйл ажиллагаандаа ашиглана.	

Үйл ажиллагааны зардал	Төслийн нээлт, хаалт	удаа	2	100000	200 000	Урилга, цайны материалд зарцуулна.
	Уулзалтын зардал	удаа	10	10000	100 000	СЭЭБХ-ны УЗ, бусад оролцогчид бэлтгэл уулзалтууд зохион байгуулна.
	Дүгнэх уулзалтын зардал	удаа	3	20000	60 000	Төслийн хугацаанд 3 удаа дүгнэх уулзалтыг зохион байгуулна.
	Харилцаа холбооны зардал	10 хүн	13 сар	3000	390 000	СЭЭБХ-ны гишүүн төлөөлөлд зориулна.
	Банкны шимтгэл				30 000	Гүйлгээ хийэд зарцуулагдана.
Бүгд					527356 0	2000 ам.долларыг 2018.12.18-ны өдрийн Монгол банкны ханш: 2636,78 төгрөгөөр тооцов.

Хэсэг VI Төслийн тогтвортой байдал

1. Өөрсдийн нөөц боломжид тулгуурлан тоглоомоо баяжуулан ашигласнаар сургалтын чанарт ахиц гарч үр дүн дээшилнэ.
2. Хүүхэд бүр хичээлдээ сонирхолтой болж сургуульдаа дуртай ирдэг болно.
3. Эцэг эхчүүд багштай хамтран ажиллаж өөрсдийн хийсэн тоглоомондоо анхаарал хандуулан сургууль дээр ирж хичээлд суудаг багшаас зөвлөгөө авдаг болно.
4. Эцэг эх багш нараас бүрдсэн зөвлөн туслах багтай болж цаашид хамтран ажиллана.
5. Ханын тоглоомоо цаашид баяжуулан ашиглана.
6. Анги дэвшин суралцах ба шинээр элсэн орж буй хүүхэд бүр дадлагажин сайжруулах хичээлээр өөрийн олж авсан мэдлэгээ амьдралдаа хэрэгжүүлэх, хэрэглээ болгон урам зоригтой сурч боловсрох нөхцлийг бий болгож байгаагаараа илүү тогтвортой чухал асуудал юм.

